

АУГАА ИХ ОКТЯБРИЙН
70 ЖИЛИЙН ОЙД

**ЭНХ ТАЙВНЫ ТУХАЙ
ЛЕНИНИЙ ТУНХАГ, ЭРИН ҮЕ**

Дэлхий дахины нийгэм улс төрийн өнөөгийн дүр төрх бол Аугаа их Октябрийн социалист хувьсгалаар эхэлсэн түүхэн үйл явдлын зүй тогтоолт үр дүн мөн. Их Октябрийн 70 жилийн ой өнөөдөр 80-аад оны хоёрдугаар хагаст түүхэн шинэ нөхцөлд болж байна. Энэ түүхэн шинэ үе нь ЗХУКН-ын XXVII их хурал, ах дүү социалист орнуудын коммунист намуудын сүүлчийн их хурлуудын үзэл санаагаар тодорхойлогдож байна. Аугаа их Октябрийн гандан бууршгүй үр нөлөөгөөр жигүүрлэсэн ЗХУКН-ын XXVII их хурлын үзэл санаа нь өнөөдрийн дэлхий дахины нийгэм-улс төрийн хөгжлийн замыг гэгээрүүлж, орчин үгийн олон улсын харилцааны асуудлууд, юуны өмнө, дайн энхийн асуудал, цөмийн дайны аюул заналыг арилгах тэмцэлд шинэ сэтгэлгээний үүднээс хандах аятай сайхан боломжийг нээж өглөө. Энэ тухай МАХН-ын Төв Хорооноос «Аугаа их Октябрийн социалист хувьсгалын 70 жилийн ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх тухай» тогтоолд «Зөвлөлт төр үүссэн анхны өдрөөс эхлээд энх тайван, улс түмний найрамдал, хамтын ажиллагааны тугч болж ирсэн, болж ч байна. ЗХУКН, Зөвлөлт засгийн газрын гадаад бодлогын стратегийн үндсэн зорилго, чиглэлд шинэлэг бодитой үзэл санаа, дайн энхийн асуудалд хариуцлагатай хандсан чанарын хувьд шинээр шийдэх аргыг эрж сүвэгчлэх хандлага нэвт шингэжээ» гэж дүгнэн тэмдэглэлээ.

Аливаа нийгэм, улс төрийн асуудалд цаг ямагт шинэ сэтгэлгээгээр халах үүднээс улс орны гадаад, дотоод хийгээд олон улсын бодлого явуулж байхын яруу сайхан үлгэр жишээг В.И. Ленин эв хамт «большевикуудын» нам, Зөвлөлт төрийн бүхий л үйл ажиллагаа тод харуулж өгсөн билээ. Одоогоос 70 жилийн өмнө 1917 оны 11-р сарын 8-нд бүх Оросын ажилчин, цэргийн депутатуудын зөвлөлүүдийн хоёрдугаар их хурлаас түүхэн чухал баримт бичиг Найрамдлын тухай хуулийг баталж, шинэ дутам тогтносон залуу Зөвлөлт Орос улс энх тайвны бодлогоо тодорхойлж, тэр үеийн олон улсын харилцаанд хүчтэй нь хүчгүйгээ дарлан ноёрхож байсан харгис бурангуй зуршлыг эрс буруушааж, харилцан тэгш бүрэн эрхт байдлаа хүлээн зөвшөөрч, энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг зарлан тунхаглажээ.

Хэрэв орчин үеийн олон улсын эрхийн томъёоллыг хэрэглэвэл, Лениний энх тайвны тунхаг улс хоорондын харилцаанд хүч үл хэрэглэх зарчим тогтоох, үндэстэн бүрийн хувь заяагаа чөлөөтэй тодорхойлох эрхийг хүндэтгэх, улс орнуудын их багын хэмжээ, газар зүйн байршил, соёл боловсрол, эдийн засгийн хөгжлийн түвшнээс хамаарахгүйгээр бүрэн эрхтэйгээр тэгш харилцах зарчмуудыг тунхаглажээ. Үүнээс үзвэл Лениний Энх тайвны тухай тунхаг зарчмын үнэлж баршгүй асар их ач холбогдолтой юм. Төрийн энэхүү аугаа их баримт бичигт хүн төрөлхтний түүхэнд анх түрүүнд булаан эзлэгч түрэмгий дайныг хүн төрөлхтний эсрэг үйлдсэн туйлын том гэмт хэрэг мөн» гэж тодорхойлсон байна. Тунхагийн ийм үзэл санаа цөмийн эрин зууны өнөө үед нийт улс түмэн тэдгээрийн эрх баригчдын улс төрийн сэтгэлгээг хөндөхгүй байж чадахгүй юм.

Найрамдлын тухай хууль бүх орон бие биенээ харилцан хүндэтгэх үндсэнд тулгуурласан тэгш эрхийн харилцаа тогтоохын чухлыг

илэрхийлсэн юм. Олон улсын амьдралд энэ үзэл санаа хөгжин нийгмийн өөр өөр байгууламж бүхий улсууд энх тайвнаар зэрэгцэн орших Ленинч зарчмын цөм нь болж байна. ЗХУ, социалист бусад орны өнөөгийн гадаад улс төрийн мөрийн хөтөлбөр уг чанартаа он цагийн шалгалтыг давсан энэхүү үзэл баримтлалыг үргэлжлүүлэн хөгжүүлсэн юм. Үүний үр дүнд анх Октябраар тунхаглагдсан энх тайвнаар зэрэгцэн орших хүнлэг зарчим эдүгээ олон улсын харилцааны нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ нэгэнт боллоо. Дэлхийн нийгмийн харилцаа энх амгалан зэрэгцэн аж төрөх, зэрэгцэн орших зарчимд тулгуурлаж чадах бөгөөд тэгэх ёстой гэж Ленин Октябрийн дараах жилүүдэд ч бичиж байлаа. Энх амгалан зэрэгцэн аж төрөх явдлыг империализм тасалдуулах гэж байнга оролдож, тэгэхдээ социализмыг дайнаар бусниулах буюу тэр ч байтугай устгах гэж санаархах болно гэдгийг тэрбээр сануулж байв. Одоогоос 70 жилийн өмнө Их Лениний сануулсан ийм байдалтай хүн төрөлхтөн өнөө үед нэгэнт тулгарсан байна. «Цөмийн зэвсэг хуримталж, боловсронгуй болохын хамт хүн төрөлхтөн мөнхөд орших бололцоогоо алджээ. .. Гагцхүү цөмийн зэвсгийг устгавал л энэ бололцоог буцаан авч болно» гэж 1987 оны эхээр Москвад болсон энх тайвны төлөө тэмцэгчдийн чуулга уулзалт дээр М. С. Горбачев хэлсэн билээ. Энэ бол өнөө үеийн эрс шаардлага, хүн төрөлхтөн эсэн мэнд байх гол нөхцөл гэдгийг орон бүхний олон нийтийн өргөн давхраа улам бүр ойлгох болов. Энэ бүхнийг иш үндэс болгож цөмийн дайнд нийтээрээ сөнөх аюул, дэлхийг хамарсан хурц хурц асуудал хуримталснаас учирч байгаа бэрхшээл, эдийн засгийн хоцрогдлыг арилгах асуудал, колонийн асуудал энэ бүхний талаар хүн төрөлхтөн нийтээрээ уялдаа холбоотойг, хүн, нийгэм, байгаль гурав дэлхий нийтийн хэмжээнд харилцан шүтэлцээтэйг гүйцэд ухаарах хэрэгтэй гэсэн дүгнэлтийг ЗХУКН, ах дүү бусад нам хийсэн билээ.

Цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулж, улс түмний энх тайвныг сахин хамгаалах талаар ЗХУ, социалист бусад орны дэвшүүлсэн шинэ санал, санаачилгууд дэлхийг цөмийн аюулаас аврах үндсэн замыг тодорхойлж Лениний энх тайвны тунхагийн гандан бууршгүй үзэл санааг шинэ нөхцөлд шинэ сэтгэлгээгээр үргэлжлүүлж байна. Зөвлөлт Холбоот Улсын дэвшүүлсэн цөмийн болон үй олноор хөнөөгч бусад зэвсгийг энэ зууны эцэс гэхэд шатчилан устгасан байх Програмын хүрээнд ЗХУ социалист хамтын нөхөрлөлийн бусад орнуудаас олон чухал санал, санаачлага дэвшүүлснийг энхийг эрхэмлэгч бүх хүчин түүний дотор Монголын ард түмэн халуунаар сайшаан дэмжиж байна.

Варшавын гэрээнд оролцогч улсуудын улс төрийн Зөвлөлдөх хорооны Берлинд болсон (1987) зөвлөлгөөний дүн, түүний баталсан баримт бичгүүд, ялангуяа Варшавын гэрээнд оролцогч улсуудын цэргийн номлолын тухай заалтууд нь социализмын энх тайванч гадаад бодлогын тодорхой илрэл төдийгүй дэлхий дахины хурцадмал байдлыг намжаах үйлсэд дорвитой хувь нэмэр оруулах зарчмын ач холбогдолтой юм.

Бүх нийтийн энх тайван, түүний дотор Азийн аюулгүй байдал бол үл хуваагдах нэгдмэл, салшгүй уялдаатай учраас Ази, Номхон далайн бүс нутаг дэлхийн бодлогод чухал байр эзэлж байна. Империализм, юуны өмнө Америкийн империализмийн дэлхийд ноёрхох шинэ үзэл»-ийн уршгаар тус бүс нутгийн байдал улам хурцдаж түгшүүртэй байдал нь даамжирсаар байна. Иймээс Ази, Номхон

далайн бүс нутгийн улс түмний аюулгүй байдлыг олон улсын харилцааны нэгдмэл, олон талт байдалд нийцүүлэн цөмийн дайны эсрэг, бүх нийтийн энх тайвны төлөө тэмцэлтэй нягт холбоотой шийдвэрлэх ёстой. ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга нөхөр М. С. Горбачев 1986 оны 7-р сарын 28-нд Владивостокт хэлсэн үгэндээ Зүүн өмнөд Ази, Афганистаны байдлыг зохицуулах, Солонгосын хойгийн түгшүүртэй байдлыг намжаах, цөмийн зэвсэг дэлгэрүүлэх явдлыг газар авахуулах замд хориг тавих, Номхон далайд цэргийн флотын идэвхжлийг багасгах, Энэтхэгийн далайг энх тайвны бүс болгох, Азид зэвсэгт хүчин, ердийн зэвсэглэлийг хорогдуулах, энэ бүс нутагт итгэлцэх, хүч үл хэрэглэх арга хэмжээ боловсруулах зэрэг маш үнэтэй чухал программ дэвшүүлсэн билээ. Энэ программыг хэрхэн амьдралд хэрэгжүүлэх, түүний тул ямар алхам хийх ёстойг М. С. Горбачев Индонезийн «Мердека» сонины асуултанд өгсөн хариундаа улам тодорхой илэрхийллээ.

Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, түгшүүртэй байдлын голомтыг устгах, сайн хөршийн харилцаа хөгжүүлэхэд чиглэсэн өргөн цар хүрээтэй дээрх санал нь тус бүс нутгийн энхийг эрхэмлэгч бүх хүчний эрх ашигтай яв цав нийцэж байна.

Дэлхий ертөнцийг цөмийн зэвсэггүй, хүчирхийлэлгүй болгох зарчмын тухай Зөвлөлт-Энэтхэгийн «Делийн тунхаглал», эвсэлд нэгдээгүй орнуудын бодлого, чиг шугамд дээрх санал мөн тод томруун тусгалаа олж хэрэгжиж байна.

Ер нь сүр далайлгах, хүч хэрэглэх буюу хэрэглэхээр заналхийлэх балмад бодлогыг олон улсын харилцааны практикаас бүрмөсөн арилгах, ингэж түрэмгий авирлахын материаллаг үндэс болсон зэр зэвсэг, юуны өмнө цөмийн зэвсгийг устгах хэрэгтэй гэдгийг дэлхийн өргөн олон нийтийн санал бодол цөхрөлтгүй дахин давтан анхааруулж байна. Үүнийг 1987 оны хоёрдугаар сард Москвад болсон энх тайвны төлөө тэмцэгчдийн чуулга уулзалтын бүхий л явц, дүн бүр ч тодорхой харууллаа.

МАХН-ын XIX их хурал, «Ази тивд харилцан ойлгох, сайн хөрш байх, хамтран ажиллах, улс төрийн өргөн яриа хэлэлцээ хийх, маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх замаар л бат бэх, найдвартай энх тайван тогтоож болно» гэж үзсэн билээ.

МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж. Батмөнх, МАХН-ын Төв Хорооны Ш бүгд хурал дээр хэлсэн үгэндээ «Дэлхий болон Азийн энх тайван, аюулгүй байдлыг хамгаалахад чиглэгдсэн ЗХУ, ах дүү социалист орнуудын мятрашгүй хүчин чармайлтыг БНМАУ бүрэн дүүрэн дэмжиж түүнд чадлынхаа хэрээр тус дөхөм үзүүлэхэд өөрөөсөө хамаарах бүхнийг хийх болно гэдгийг онцлон тэмдэглэв.

Улс хоорондын харилцаанд хүч үл хэрэглэх зарчмыг хэлбэрэлтгүй мөрдлөг болгох явдал нэн чухал ач холбогдолтой. БНМАУ уг зарчмыг манай тив, бүс нутгийн хэмжээнд хууль зүйн нэмэлт баталгаатай бол гох үүднээс тодорхой санал дэвшүүлсэн нь дэлхийн олон нийтийн өргөн дэмжлэг хүлээж байна. Ази, Номхон далайн улс хоорондын харилцаанд хүч үл хэрэглэх механизм бий болгох тухай БНМАУ-ын санал ах дүү социалист болон энхийг эрхэмлэгч бусад орнуудын оновчтой санал санаачлагатай бүрэн уялдаж байгаа юм.

Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангах талаар ЗХУ-ын авч байгаа практик арга хэмжээг манай улс

талархан дэмжиж, энэ үйл хэрэгт хувь нэмрээ оруулахыг чармайж байна. Үүний нэг жишээ нь хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр БНМАУ-д манай засгийн газрын хүсэлтээр түр байрлаж байгаа Зөвлөлтийн цэргийн нэлээд хэсгийг энэ оны дөрөв, зургадугаар сард эх оронд нь үдсэн явдал юм. Манай орны нутагт түр байрлаж байгаа Зөвлөлтийн цэргийн зарим хэсгийг ийнхүү гаргасан нь Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, олон улсын аюулгүй байдлын бүх нийтийн системийн үндэс бий болгох үүднээс дэвшүүлсэн зөвлөлтийн өргөн хүрээтэй санаачлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой алхам мөн.

Энх тайван, аюулгүй байдлыг хангахад улс гүрэн бие биеэ ойлгох, учир зүйгээ олох, яриа хэлэлцээ хийх, зөвлөлдөх, харилцан ойртох, итгэлцэх явдал маш чухал гэж БНМАУ үздэг. Энэ үүднээс манай нам, төр, олон нийтийн байгууллагууд өргөн хүрээтэй, олон талтай ажил зохиож байна.

МАХН Ази, Номхон далайн улс хоорондын харилцаанд хүч үл хэрэглэх үзэл санааг улам бэхжүүлэх, энх тайван, аюулгүй байдлын төлөө янз бүрийн нам, хүч, хөдөлгөөний эв нэгдлийг бэхжүүлэх, тив, бүс нутгийн улс төрийн уур амьсгалыг эрүүлжүүлэх талаар цуцалтгүй ажиллан тодорхой практик арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Монголын парламент, энх тайван, найрамдлын байгууллагуудын холбоо, олон нийтийн бусад байгууллагуудын шугамаар нэлээд өргөн арга хэмжээ, практик алхамуудыг хийж байна. Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын асуудлаар энэ онд манай оронд болсон олон улсын үйлдвэрчний эвлэлийн уулзалт-ярилцлага, оюутан залуучуудын олон улсын уулзалт чухал үр дүнтэй боллоо. Түүнчлэн энэ оны 7-р сарын эхээр Улаанбаатар хотноо амжилттай болсон Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын коммунист, ажилчны болон хувьсгалт-ардчилсан намуудын төлөөлөгчдийн зөвлөлдөх уулзалт бүс нутгийн болон дэлхий дахины энх тайван аюулгүй байдал, улс орнуудын сайн хөршийн хамтын ажиллагааны төлөө тэмцлийг бэхжүүлэхэд чиглэсэн ах дүү намуудын хамтын ажиллагааг улам өргөжүүлэх үйлсэд чухал хувь нэмэр оруулсан уг районы коммунист, ажилчны намуудын хамтын ажиллагааны түүхэн дэхь анхны арга хэмжээ боллоо.

Уулзалтад оролцсон намуудын төлөөлөгчид социалист улсууд, Ази, Номхон далайн бусад улсын болон энхийг эрхэмлэгч хүчин, олон нийтийн хөдөлгөөний оновчтой санаачилга, үйл ажиллагааг энх тайван, олон улсын аюулгүй байдлын төлөө тэмцэлд оруулж байгаа чухал хувь нэмэр гэж үзэж бүрэн дэмжээд бүс нутгийн янз бүрийн хэсэгт цөмийн зэвсэггүй, энх тайвны бүс байгуулах саналтай байгаагаа илэрхийллээ.

«Дэлхийн бодлогод манай нам, төр энхийг эрхэмлэсэн чиг шугам, тууштай дуулж байна. Бид улс төрийн шинэ сэтгэлгээг удирдлага болгож, олон улсын асуудалд уян хатан, бодитой хандаж байна. Гурав дахь “мянган жилийн босгон дээр улс орнууд цөмийн дуулгаа хөсөр хаях, сансарт зэвсэг гаргахгүй байх, газар дэлхий дээр түүнийг хорогдуулан, эцсийн бүлэгт устгахад ажил төрлөө хэлбэрэлтгүй хандуулах болно гэж аугаа их Октябрийн 70 жилийн ойг угтаж ЗХУКН ын Төв Хорооноос зөвлөлтийн ард түмэнд хандаж гаргасан уриалгад өгүүлжээ.

ЗХУКН, ЗХУ-ын засгийн газар олон улсын үйл ажиллагаанд энэхүү эрхэм дээд зорилгын үүднээс ялгуулсан Октябрийн гадаад бодлогын анхны баримт бичиг болсон энх тайвны тунхагийн үзэл санааг түүхэн хөгжлийн явцад улам баяжуулан хөгжүүлж, орчин үеийн дэлхий дахинд энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, энхийг эрхэмлэгч бүх хүчнийг энэ чигт нэгтгэн нягтруулахад онцгой чухал үүрэг роль гүйцэтгэж ирсэн, гүйцэтгэсээр ч байна.